

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 25 өдөр

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хүрсэн үр дүн	Хувь
1	2	3	4	5
1.1.	<p>Авлигатай Тэмцэх газраас бэлтгэсэн шторк, видео график, нийтлэл, төлө зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын цахим хуудас, нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулж мэдээлэх;</p>	<p>Нэг Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p> <p>Авлигатай тэмцэх газраас албан тушаалтнуудын 2022 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг бүртгэх, хүлээн авах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд мэдүүлэг гаргагч нарт https://www.youtube.com/watch?v=IbU7wqKF5-o, https://www.youtube.com/watch?v=ELtmj5-svPE хаягаар нэвтрэн мэдээлэл, видео сурталчилгаатай танилцаж, 2022.02.15-ны дотор ХАСХОМ гаргах тухай зааварчилгааг Комиссын цахим хуудас болон пейж хуудсанд байршуулж, мэдээллээр хангасан. 2/ "Авлигатай тэмцэх 5Ш ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "Шүгэл" ажиллагааны хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс улс орон даяар зохион байгуулагдаж байгаа "Нэгдье" аяны хүрээнд АТГ-аас ирүүлсэн соён гэгээрүүлэх сурталчилгааны постер, шторкийг Комиссын цахим хуудас болон фейсбүүк хуудсанд байршуулж, нийтэд түгээсэн. ХЭҮК-оос "Нэгдье" аяны хүрээнд авлигын үр дагавар, хор уршиг нь ямагт хүний эрхийн зөрчлийг бий болгодог тухай 2 төрлийн постер хийж байгууллагын цахим хуудас болон фейсбүүк хуудас, орон нутгийн ажигтнуудаар дамжуулан олон нийтэд түгээж, сурталчилсан. "5Ш" ажиллагааны хүрээнд 3Г-аас авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар 14 хоногийн мэдээ, ЦХХХЯам-наас ирүүлсэн тойм мэдээллийг тус тус байгууллагын цахим хуудсанд тухай бүр мэдээлсэн.</p>	<p>Байгууллагын цахим хуудас, нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулж нийтэд сурталчилж, түгээсэн.</p>	100%

1.2.	<p>Авлигатай тэмцэх газартай хамтран авлига ба хүний эрх сэдэвт сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;</p>	<p>Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа хугацаат цэргийн нэгтгэл, ангидын захирагч, эрх бүхий албан тушаалтан нарыг хамруулсан "Цэргийн анги дахь ашиг сонирхол ба хүний эрхийн зөрчил" сэдэвт уулзалтад Комиссын гишүүн Б.Энхболд оролцож "Цэргийн албан хаагчийн эрхийн хэрэгжилтийн байдал" сэдвээр мэдээлэл хийсэн.</p>	<p>Батлан хамгаалах салбарт цэргийн албан хаагчийн эрхийг хамгаалах асуудлаар холбогдох мэдлэг ойлголт өгсөн.</p>	100%
1.3.	<p>"Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарт байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээллийг байршуулах;</p>	<p>Авлигатай Тэмцэх газраас гаргасан "Шударга ёс хөгжил дэвшил" нэгдсэн самбар 3Г-ын 12 дугаар байранд 3 байгууллага хамтран ашигладаг бөгөөд тайлант хугацаанд АТГ-ын сар бүрийн статистик мэдээ болон "5Ш" ажиллагааны хүрээнд 3Г-аас авлигын эсрэг үйл ажиллагааны 14 хоногийн мэдээг тус тус байршуулсан. Түүнчлэн ХЭҮК-ын "Нэгдье" аяны хүрээнд гаргасан 2 постерыг байршуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Монгол Улсын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын Мэдээллийн самбарт байршуулсан.</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар иргэд, олон нийт бодит мэдээллээр хангагдсан.</p>	100%
Хоёр. Авлигын эсрэг сургалт зохион байгуулалтад албан хаагчдыг хамруулах				
2.1.	<p>Нийтийн албанд шинээр томилогдсон мэдүүлэг гаргагч нарт зориулсан болон авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх сургалтад албан хаагчдыг хамруулах;</p>	<p>1/Авлигатай тэмцэх газраас 2023.05.29-ний өдөр, 2023.09.26-ны өдөр "Zoom"-ээр зохион байгуулсан 2023 онд шинээр томилогдсон мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтад Тамгын газрын ЭБАТ хамрагдаж, мэдээлэл авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан. 2/Төрийн албаны зөвлөлийн 2023.03.10-ны өдрийн 7.4:10 цахим сургалтаар Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн төслийн талаар мэдээлэл өгөх цахим сургалтад 4 албан хаагч хамрагдсан. 3/ Удирдлагын академийн төрийн албаны эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5,</p>	<p>Авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлсэн.</p>	100%

	<p>Төрийн албанд анх томилогдох иргэнийг чиглүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. Тус сургалтад Ёс зүйн хичээл орсон. 4/ Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулан гаргасан цахим сургалтуудаас "Авлигаас ангид төрийн албан хаагч", "Ёс зүй" сэдэвт 3 түвшний цахим сургалтад 6 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.</p>		
<p>2.2. Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуула бүхий цахим гарын авлага бэлтгэж албан хаагчдад хүргэсэн байх;</p>	<p>ХЭҮК-оос "Нэгдье" аяны хүрээнд авлигын үр дагавар, хор уршиг нь ямагт хүний эрхийн зөрчлийг бий болгодог тухай 2 төрлийн постер хийж байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудас, мэдээллийн самбарт байршуулж, орон нутгийн ажилтнуудаар дамжуулан аймаг орон нутагт олон нийтэд түгээж, сурталчилсан.</p>	<p>Албан хаагчдад авлигын эсрэг ойлголт, хандлагыг төлөвшүүлсэн.</p>	<p>90%</p>
<p>Гурав. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх</p>			
<p>3.1. Мэдүүлэг гаргагч, албан тушаалтны 2022 оны шинэчилсэн мэдүүлгийг бүртгэж, арга зүйн зөвлөгөө өгч, хянаж баталгаажуулан тайланг нэгтгэж холбогдох байгууллагад хүргэх;</p>	<p>1. Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2022 оны тайлан (ХАСХОМ-1)-г холбогдох маягтын дагуу гаргаж цаасаар, ХАС болон ХОМ-ийн хураангуй тайланг https://meduileg.iaac.mn/ системээс татаж pdf файлаар elkhii@iaac.mn и-мэйл хаягаар тус тус илгээсэн.</p> <p>2. Гэрээ байгуулах чиг үүргийн хүрээнд нийт 76, төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах чиг үүргийн хүрээнд 25 ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл, тайлбар гаргасныг бүртгэлжүүлсэн.</p>	<p>Хуулийн хэрэгжилт хангагдсан.</p>	<p>100%</p>
<p>3.2. Нийтийн албанд шинээр томилогдох албан тушаалтнуудын урьдчилсан мэдүүлгийг хянуулах, ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн ажигд томилох, томилогдсоноос хойш 30 хоног дотор мэдүүлгийг гаргуулах, цахимаар тайлагнах арга хэмжээг авах;</p>	<p>1. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 25 этгээдийн урьдчилсан мэдүүлэг хянаж баталгаажуулсан ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох албан тушаалд томилсон.</p> <p>2. Томилогдсоноос хойш 30 хоног дотор 13 албан хаагч мэдүүлэг гаргасныг хугацаанд цахим системд хянаж баталгаажуулсан.</p>		<p>100%</p>

3.3. ХАСХОМ болон ХАСУМ-тэй холбоотой бүртгэлийг цахим системд оруулж, хянаж баталгаажуулах.	ХАСХОМ болон ХАСУМ-тэй холбоотой бүртгэлийг цахим системд тайлант хугацаанд нь оруулж, хянаж баталгаажуулсан.		100%
Дөрөв. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох			
4.1. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр байгуулсан аливаа гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар холбогдох заалтыг нэмж тусгах;	Байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар нийт 76 гэрээ байгуулагдсан бөгөөд гэрээ бүрд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг Тамгын газрын дарга болон гэрээ байгуулсан хэлтсийн дарга нар тухай бүр гаргасныг medshleg.iaas.mn цахим системд тайлагнасан.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлсэн.	100%
4.2. Комисст иргэдээс ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийг хянах, олон нийтэд ил тод мэдээлэх, цахим систем хэрэглээнд нэвтрүүлж мэдээллийн сан байгуулах;	Иргэдийн гомдлын шийдвэрлэлтийг хянах, ямар албан тушаалтанд хуваарилгагдсан, хугацаанд нь шийдвэрлэж байгаа эсэх талаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Гомдлын шийдвэрлэлтийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хэрхэн ангилан бүртгэх болон гомдол шийдвэрлэх явцад ямар төлөвт хэрхэн шилжиж байх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, Комиссын сайтыг шинэчлэх асуудлаар гүйцэтгэгч байгууллагатай хамтарсан уулзалт хийж харилцан санал солилцож, систем хөгжүүлэлтийн ажил хийгдэж эхэлсэн. Тайлант хугацаанд хүний эрхийн асуудлаар нийт 659 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 604 буюу 91,6 хувийг шийдвэрлэсэн байна.	Иргэдийн гомдлын шийдвэрлэлтийн талаар мэдээлэл авах эрх хангагдсан.	100%
Тав. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, хүсэл эрмэлзлэл, санаачилга өрнүүлэх			
5.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэх;	ХЭУК-оос "Нэгдье" аяны хүрээнд авлигын үр дагавар, хор уршиг нь ямагт хүний эрхийн зөрчлийг бий болгодог тухай 2 төрлийн постер хийж байгууллагын цахим хуудас болон фейсбүүк хуудас, орон нутгийн ажигтнуудаар дамжуулан олон нийтэд түгээж, сурталчилсан. "Авлигатай тэмцэх таван ажиглага"-ны нэг арга хэмжээ болох "Шүтэл" ажиглагааны хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс улс орон даяар зохион байгуулагдаж байгаа "Нэгдье" аяны хүрээнд АТГ-	Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд байгууллага хамт олноороо нэгдэх арга хэмжээ хэрэгжүүлсэн.	100%

		аас ирүүлсэн соён гэгээрүүлэх сурталчилгааны постер, шторжийг Комиссын цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулж нийтэд түгээсэн.		
5.2.	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	Байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар нийт 76 гэрээ байгуулагдсан бөгөөд гэрээ бүрд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг Тамгын газрын дарга болон гэрээ байгуулсан хэлтсийн дарга нар тухай бүр гаргасныг meduileg.iaas.mn цахим системд тайлагнасан	Хуулийн хэрэгжилт хангагдсан.	100%
5.3.	Авлигын эсрэг үйл ажиллагааны байгууллагын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авах;	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд хэлтэс бүр төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүр нь хэрэгжүүлсэн.	100%
5.4.	Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас "Шүүр" ажиллагааны хүрээнд зохион байгуулж байгаа арга хэмжээнд нэгдэж, удирдлагын зүгээс манлайлах;	Төрийн албаны зөвлөлийн 2023.01.17-ны 01/121 тоот албан бичиг, 2023.01.11-ний өдрийн Мэдэгдлийн хэрэгжилтийг хангах хүрээнд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа 2022.12.31-ний өдөр дуусгавар болсонтой холбогдуулан тус хуулийн хүрээнд томилогдсон 3 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлсөн. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны зөвлөлд 8 удаа явуулсан. Удирдах албан тушаалд 2, гүйцэтгэх албан тушаалд 15 албан хаагч сонгон шалгаруулалтад оролцож, тэнцсэн. Үүнээс байгууллага дотроо ажиллаж байгаа 11 албан хаагчийг шатлан дэвшүүлж томилсон. 6 албан хаагчийг төрийн бусад байгууллага болон төрийн албанд анх орох иргэний нөөцөөс сонгон шалгаруулж томилсон. ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолын дагуу төрийн бусад байгууллагад ижил ангиллын албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдаас сул орон	Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас "Шүүр" ажиллагааны хүрээнд зохион байгуулж байгаа арга хэмжээнд нэгдэж, удирдлагын зүгээс манлайлах;	100%

		<p>Тоог нөхөх хүрээнд тусгай шаардлага хангаж байгаа 1 албан хаагчийг Ахлах түшмэлийн албан тушаалд шилжүүлэн томилсон. Төрийн албаны 4 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулж, тайланг ТАЗ-ийн хуралд танилцуулж, гарсан тогтоолын дагуу нийт 13 хүнийг Тамгын даргын тушаалаар холбогдох ажлын байранд томилсон.</p>		
Зургаа Авлига, ашиг сонирхлын зөрчилт үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах				
6.1.	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх/</p>	<p>Иргэдийн Комисст хандаж гаргасан гомдлын шийдвэрлэлтийг хянах, ямар албан тушаалтанд хуваарилгдсан болох, хугацаанд нь шийдвэрлэж байгаа эсэх талаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Гомдлын шийдвэрлэлтийн цахим систем хэрэглээнд нэвтрүүлж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, Комиссын сайтыг шинэчлэх асуудлаар гүйцэтгэгч байгууллагатай хамтарсан уулзалт хийж иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хэрхэн ангилан бүртгэх болон гомдол шийдвэрлэх явцад ямар төлөвт хэрхэн шилжиж байх талаар харилцан санал солилцож, шинэчлэлийг хийхээр холбогдох систем хөгжүүлэлт хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.</p>	<p>Иргэд өргөдлийн шийдвэрлэлтийн явцад өөрөө хяналт тавих боломж бүрдсэн.</p>	100%
6.2.	<p>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоо нэвтрүүлж үйлчилгээг сайжруулах;</p>	<p>Хүний эрхийн зөрчлийн талаар иргэдээс ирүүлэх гомдол мэдээллийг 70000222 тусгай дугаар, цэргийн жинхэнэ алба хаагчидтай холбоотой гомдол, мэдээллийг 92050222 дугаарын утсаар хүлээн авч байна. Түүнчлэн ХЭҮК-ын цахим хуудас www.lhsgt.gov.mn/ болон пэйж хуудсаар өргөдөл хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх тусгай цэс ажиллуулж, хариуцсан ажилтныг үүрэгжүүлэн, тухай бүрд шуурхай, бүртгэж холбогдох ажилтанд шилжүүлж, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох иргэнд албан бичгээр болон утсаар, биечлэн байдлаар шийдвэрлэсэн хариуг мэдэгдсэн. Тайлант хугацаанд хүний эрхийн асуудлаар нийт 659 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 604 буюу 91.6 хувийг шийдвэрлэсэн байна.</p>	<p>Жилийн эцсийн байдлаарх өргөдлийн шийдвэрлэлтийн хугацаа, чанарт явцын хяналт хийж, Комиссын хуралд танилцуулсан.</p>	90%

	<p>7.1. Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, цахим хуудсыг шинэчлэх өргөжүүлэх;</p>	<p>Байгууллагын цахим хуудсанд -2022-2025 оны стратеги төлөвлөгөө, -Гүйцэтгэлийн төлөвлөгөөний - 5, -Үйл ажиллагааны тайлан - 13, -Хяналт шинжилгээ, үнэлгээний - 8, -Статистик тоо, мэдээ – 6, -Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм – 3, - Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан мэдээ -2, - Авлига, соён гэгээрүүлэх ажиллагаа-3, -Зарлал – 2, -Онцлох мэдээ – 2 нийт 45 удаагийн мэдээ, мэдээлэл байршуулан ажилласан байна. Комиссын цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбогдуулан Хүний нөөцийн ил тод байдал, Авлига, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа цэсэнд холбогдох мэдээлэл болон Эрх зүйн, мэдээллийн нэгдсэн систем, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсыг тус тус холбосон. Комиссын 2022-2025 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2022, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2013-2022 оны үйл ажиллагааны тайлан, 2016-2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг байгууллагын шинэчлэгдсэн цахим хуудаст байршуулж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан. 2. ХЭҮК-ын 2022 оны бүтэн жил, 2023 оны 01 дүгээр улирал, 05 дугаар сарын байдлаарх үйл ажиллагааны статистикийг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн, мэдээллийн постер бэлтгэж байгууллагын цахим хуудас, facebook, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд сурталчилсан.</p>	<p>Байгууллагын цахим хуудсанд Гомдол гаргах журам, гомдол шийдвэрлэх явц, гомдол мэдээллийн шийдвэрлэлт зэрэг цонхыг нээж ажиллуулсан. Бидний тухай цонхонд хэлтсийн нэр, чиг үүрэг, албан хаагчдын мэдээлэл, албан тушаалын тодорхойлолтыг байршуулсан.</p>	<p>Байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний нэр төрөл, төлбөр, хураамж, холбогдох дүрэм журам, цагийн хуваарь, албан хаагчдын мэдээлэл зэргийг цахим хуудас байршуулж, шинэчилсэн.</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдээллийг нээлттэй байлгаж, цахим хуудсыг шинэчилсэн.</p>	<p>100%</p>
--	--	--	---	---	--	-------------

7.2.	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах;</p>	<p>Санхүүгийн ил тод байдлыг хангах асуудлаар shlendans.gov.mn цахим хуудсаар болон Комиссын nhsmt.gov.mn цахим хуудсанд шилэн данс цэсээр холбож шилэн дансны мэдээллийг байршуулж байна. Тайлант хугацаанд 161 мэдээллийг бүрэн, хугацаанд нь байршуулан ажигласан. Комиссын цахим хуудсанд Худалдан авах ажиглагааны ил тод байдлын мэдээллийг байршуулсан байна.</p>	<p>Санхүүгийн ил тод байдлыг хангасан.</p> <p>100%</p>
<p>Найм. Төрийн албан хаагчийн ёс зүй, харьцаа хандлагыг дээшлүүлэх</p>			
8.1.	<p>Нийтийн албанд томилгодох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилон, дэвшүүлэх;</p>	<p>Албан хаагчдыг ёс зүйн зөрчил, сахилгын шийтгэл хүлээсэн эсэх, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг үндэслэн, мерит зарчмыг баримтлан байгууллага дотроо ажиглаж байгаа 11 албан хаагчийг шатлан дэвшүүлж томилсон. 6 албан хаагчийг төрийн бусад байгууллага болон төрийн албанд анх орох иргэний нөөцөөс сонгон шалгаруулж томилсон.</p> <p>ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолын дагуу төрийн бусад байгууллагад ижил ангиллын албан тушаалд ажиглаж байгаа албан хаагчдаас сул орон тоог нөхөх хүрээнд тусгай шаардлага хангаж байгаа 1 албан хаагчийг Ахлах түшмэлийн албан тушаалд шилжүүлэн томилсон.</p>	<p>Албан хаагчид төрийн албанд шатлан дэвших боломжийг хангасан.</p> <p>100%</p>
8.2.	<p>Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;</p>	<p>Тамгын газрын 7 албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хянаж шалгасан. Үүнээс 1 албан хаагчийнх цуцлагдсан, 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан, 1 албан хаагчтай холбоотой гомдол ажиглагаанд, 3 албан хаагчтай холбоотой өргөдөл гомдолд хариу хүргүүлсэн. Ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн ажил үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн 2 албан хаагчид Тамгын газрын даргын тушаалаар үндсэн цалинг 3 сарын хугацаатай 20</p>	<p>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажигласан.</p> <p>90%</p>

Хувь хасах сахилгын шийтгэл ногдуулж, 1 албан хаагчид Сануулах хуудас өгч, 3 ажилтанд Тэмдэглэлээр сануулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан Тамгын даргын 2023.11.16-ны өдрийн А/113 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороо байгуулагдсан бөгөөд 2 албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг шалгаж, дүгнэлтийг холбогдох албан хаагчдад бичгээр танилцуулж, хүлээлгэж өгсөн.

Нийт дүн

98,5%

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ш.ҮНЭНТӨГС

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

О.НАРАНБАЯР

